



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЗАВХАНМАНДАЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.БАЯНАА-Д

2025.02.17 № 130

талай _____ ны № _____ ч

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завханмандал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завханмандал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Завханмандал сумын Хүүхдийн цэцэрлэг нь аймгийн Засаг даргын Тамгын газраас нийлүүлэгдсэн 17,022.7 мянган төгрөгийн 6 ширхэг зөөврийн компьютер, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5,000.0 мянган төгрөгийн биеийн тамирын заалны тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, хөрөнгө оруулалтаар ирсэн 568.0 мянган төгрөгийн дээжийн хөлдөөгч зэргийг данс бүртгэлд тусгажээ. Тус цэцэрлэг нь 5757 м.кв газрыг боловсролын байгууллагын чиглэлээр 60 жилийн хугацаанд эзэмшихээр 11,514.0 мянган төгрөгөөр үнэлэн гэрчилгээжүүлж, бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Завханмандал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар бүлгийн багш арга зүйчээр дэвшин ажиллахад үр дүнгийн урамшуулал олгосон, ажилчдад илүү цагийн нэмэгдлийг эрхлэгчийн болон бусад холбогдох байгууллагын шийдвэргүйгээр хавтгайруулан олгосон, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 52 нэр төрлийн 49,984.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгах, дахин үнэлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Завханмандал сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 100 хувьтай байна. Тайлант онд 15 орон тоотой, 566,470.8 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй, 564,692.1 мянган төгрөгийн зарцуулалттай ажиллажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	140,030,895.65	148,979,940.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,379,654.52	35,158,367.96
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	33,379,654.52	35,158,367.96
3121	Төгрөг	33,379,654.52	35,158,367.96
31211	Төрийн сангийн харилцах	33,379,654.52	35,158,367.96
33	АВЛАГА	35,558.33	35,558.33
335	Бусад авлага	35,558.33	35,558.33
3351	Байгууллагаас авах авлага	35,558.33	35,558.33
35	БАРАА МАТЕРИАЛ	106,615,682.80	113,786,013.80
351	Түүхий эд материал	5,334,900.00	5,699,400.00
3511	Тусгай зориулалттай материал	3,926,900.00	4,291,400.00
3513	Эм боох материал	1,408,000.00	1,408,000.00
354	Хангамжийн материал	101,280,782.80	108,086,613.80
3541	Бичиг хэргийн материал	993,700.00	1,229,000.00
3542	Аж ахуйн материал	295,400.00	373,850.00
3545	Барилгын засварын материал	3,032,600.00	3,032,600.00
3546	Хүнсний материал	4,653,359.00	3,738,640.00
3547	Бусад хангамжийн материал	92,305,723.80	99,712,523.80
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,242,700,093.56	1,250,857,747.38
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,242,700,093.56	1,250,857,747.38
392	Биет хөрөнгө	1,230,238,177.14	1,238,558,331.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,364,342,418.00	1,364,342,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-173,805,380.72	-185,036,862.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,080,933.00	82,651,653.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,190,825.32	-37,809,161.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,428,074.36	40,123,074.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,957,962.98	-27,053,711.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	252,000.00	252,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-252,000.00	-252,000.00
39217	Ном	1,340,920.80	1,340,920.80
393	Биет бус хөрөнгө	12,461,916.42	12,299,416.38
39301	Програм хангамж	1,950,000.00	1,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,002,083.58	-1,164,583.62
39303	Бусад биет бус хөрөнгө	11,514,000.00	11,514,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,382,730,989.21	1,399,837,687.47
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,382,730,989.21	1,399,837,687.47
51	Засгийн газрын хувь оролцоо	1,382,730,989.21	1,399,837,687.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,837,596.00	37,837,596.00

51101	Өмч: - төрийн	37,837,596.00	37,837,596.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,344,443,066.21	1,361,549,764.47
5121	Өмнөх үеийн үр дүн	1,344,443,066.21	1,344,443,066.21
5122	Тайлант үеийн үр дүн		17,106,698.26
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	450,327.00	450,327.00
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,382,730,989.21	1,399,837,687.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	444,114,839.00	599,113,370.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,834,739.00	32,642,570.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,834,739.00	32,642,570.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	17,574,263.00	25,265,720.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,260,476.00	7,376,850.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,280,100.00	566,470,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360,199,000.00	502,615,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	360,199,000.00	502,615,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,081,100.00	63,855,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,081,100.00	63,855,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	435,562,190.47	582,006,671.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,562,190.47	582,006,671.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,561,884.63	582,006,634.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,368,501.00	401,584,577.00
210101	Үндсэн цалин	191,979,484.00	254,614,578.00
210102	Нэмэгдэл	63,177,299.00	131,962,059.00
210104	Урамшуулал	11,211,718.00	15,007,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,629,908.73	50,498,409.56
210201	Тэтгэврийн даатгал	22,870,807.27	34,493,221.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,666,212.15	3,971,455.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,369,349.98	1,982,427.78
210204	Ажилгүйдлийн даатгал	510,336.45	1,980,200.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,213,202.88	8,071,103.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,358,794.16	59,322,662.82
210301	Гэрэл, цахилгаан	3,827,161.16	3,249,248.82
210302	Түлш, халаалт	48,386,057.00	55,645,414.00
210303	Цэвэр, бохир ус	145,576.00	428,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,025,213.70	5,592,420.00
210401	Бичиг хэрэг	616,300.00	1,235,130.00
210402	Тээвэр, шатахуун	1,432,910.00	2,394,770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,621,150.00	1,962,520.00
210408	Бараа материал акталсны зардал	2,354,853.70	
2105	Нормативт зардал	35,501,551.00	34,413,799.00
210502	Хоол, хүнс	35,501,551.00	34,413,799.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,730,400.00	5,534,500.00
210604	Урсгал засвар	4,730,400.00	5,534,500.00

2107	Томилолт, зочны зардал	1,634,000.00	2,107,000.00
210702	Дотоод албан томилолт	1,634,000.00	2,107,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109,500.00	2,124,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,569,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,109,500.00	555,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,204,016.04	20,829,066.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,614,700.00	203,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,123,100.00	3,517,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,466,216.04	17,108,066.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	305.84	37.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	305.84	37.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	305.84	37.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,552,648.53	17,106,698.26
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,552,648.53	17,106,698.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгсрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	417,280,100.00	566,470,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,280,100.00	566,470,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360,199,000.00	502,615,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	360,199,000.00	502,615,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,081,100.00	63,855,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,081,100.00	63,855,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	396,872,056.73	564,692,086.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	396,872,056.73	564,692,086.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,871,750.89	564,692,049.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,059,772.73	402,319,186.56
210101	Үндсэн цалин	180,679,762.73	276,854,350.56
210102	Нэмэгдэл	73,358,371.00	110,456,896.00
210104	Урамшуулал	12,021,639.00	15,007,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,892,340.00	49,754,200.00
210201	Тэтгэврийн даатгал	23,183,161.00	33,832,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,767,842.00	3,980,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,211,603.00	1,990,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	516,594.00	1,990,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,213,140.00	7,960,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,880,794.16	60,750,862.82
210301	Гэрэл, цахилгаан	4,349,161.16	4,492,448.82
210302	Түлш, халаалт	48,386,057.00	55,645,414.00
210303	Цэвэр, бохир ус	145,576.00	613,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,772,110.00	5,192,350.00
210401	Бичиг хэрэг	329,500.00	1,504,430.00
210402	Тээвэр, шатахуун	1,226,460.00	2,354,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,216,150.00	1,333,920.00
2105	Нормативт зардал	29,018,734.00	33,426,300.00
210502	Хоол, хүнс	29,018,734.00	33,426,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,200,000.00	3,104,200.00
210604	Урсгал засвар	4,200,000.00	3,104,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,634,000.00	2,107,000.00
210702	Дотоод албан томилолт	1,634,000.00	2,107,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	569,500.00	2,304,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,749,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	569,500.00	555,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,844,500.00	5,733,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,156,900.00	2,152,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,687,600.00	3,581,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	305.84	37.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	305.84	37.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	305.84	37.18
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,408,043.27	1,778,713.44
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,408,043.27	1,778,713.44
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		33,379,654.52
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		35,158,367.96

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,837,596.00	450,327.00	1,344,443,066.21	1,382,730,989.21
2	Тайлант үеийн үр дүн			17,106,698.26	17,106,698.26
3	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,837,596.00	450,327.00	1,344,443,066.21	1,382,730,989.21
4	Тайлант үеийн үр дүн			17,106,698.26	17,106,698.26
5	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,837,596.00	450,327.00	1,361,549,764.47	1,399,837,687.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	71801 - сургуулийн өмнөх боловсрол				
	80233 - хүүхэд хамгаалал				
1220	Тусламжийн орлого	484,700.00	363,500.00	121,200.00	74.99

122005	Төсвөөс санхүүжих	484,700.00	363,500.00	121,200.00	74.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	484,700.00	484,700.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	484,700.00	484,700.00		100
81605 - ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ					
1220	Тусламжийн орлого	943,400.00	942,100.00	1,300.00	99.86
122005	Төсвөөс санхүүжих	943,400.00	942,100.00	1,300.00	99.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	943,400.00	942,100.00	1,300.00	99.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	943,400.00	942,100.00	1,300.00	99.86
81807 - ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ					
1220	Тусламжийн орлого	33,279,800.00	29,631,100.00	3,648,700.00	89.04
122005	Төсвөөс санхүүжих	33,279,800.00	29,631,100.00	3,648,700.00	89.04
2105	Нормативт зардал	34,229,800.00	33,426,300.00	803,500.00	97.65
210502	Хоол, хүнс	34,229,800.00	33,426,300.00	803,500.00	97.65
81816 - ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР					
1220	Тусламжийн орлого	2,088,500.00	2,088,500.00		100
122005	Төсвөөс санхүүжих	2,088,500.00	2,088,500.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,088,500.00	2,088,500.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,088,500.00	2,088,500.00		100
81823 - БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ АЖИЛЧДЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ					
1220	Тусламжийн орлого	942,100.00	942,100.00		100
122005	Төсвөөс санхүүжих	942,100.00	942,100.00		100
2107	Томилолт, зочны зардал		340,000.00	(340,000.00)	
210702	Дотоод албан томилолт		340,000.00	(340,000.00)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	946,400.00	589,600.00	356,800.00	62.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	946,400.00	589,600.00	356,800.00	62.3
81833 - ЯВУУЛЫН БАГШИЙН ҮЙЛЧИЛГЭЭ					
1220	Тусламжийн орлого	3,564,100.00	3,564,100.00		100
122005	Төсвөөс санхүүжих	3,564,100.00	3,564,100.00		100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,376,000.00	2,362,069.00	13,931.00	99.41
210101	Үндсэн цалин	1,995,800.00	1,981,869.00	13,931.00	99.3
210102	Нэмэгдэл	380,200.00	380,200.00		100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	297,100.00	297,100.00		100
210201	Тэтгэврийн даатгал	202,000.00	202,000.00		100
210202	Тэтгэмжийн даатгал	23,800.00	23,800.00		100

210203	ҮОМШӨ-ний даатгал	11,900.00	11,900.00		100
210204	Ажилгүйдлийн даатгал	11,900.00	11,900.00		100
210205	Эрүүл мэндийн даатгал	47,500.00	47,500.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	891,000.00	891,000.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	891,000.00	891,000.00		100
81834 - БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ					
1220	Тусламжийн орлого	449,550,300.00	454,892,400.00	(5,342,100.00)	101.19
122005	Төсвөөс санхүүжих	449,550,300.00	454,892,400.00	(5,342,100.00)	101.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,749,600.00	391,973,967.56	28,775,632.44	93.16
210101	Үндсэн цалин	280,088,500.00	252,573,077.56	27,515,422.44	90.18
210102	Нэмэгдэл	137,940,800.00	132,376,100.00	5,564,700.00	95.97
210104	Урамшуулал	2,720,300.00	7,024,790.00	(4,304,490.00)	258.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,465,700.00	49,457,100.00	1,008,600.00	98
210201	Тэтгэврийн даатгал	34,317,200.00	33,630,800.00	686,400.00	98
210202	Тэтгэмжийн даатгал	4,036,800.00	3,956,600.00	80,200.00	98.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,018,600.00	1,978,300.00	40,300.00	98
210204	Ажилгүйдлийн даатгал	2,018,600.00	1,978,300.00	40,300.00	98
210205	Эрүүл мэндийн даатгал	8,074,500.00	7,913,100.00	161,400.00	98
2104	Хангамж, бараа материалын зардал		182,300.00	(182,300.00)	
210401	Бичиг хэрэг		32,300.00	(32,300.00)	
210402	Тээвэр, шатахуун		150,000.00	(150,000.00)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,169,700.00	1,169,700.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,169,700.00	1,169,700.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,589,200.00	8,649,400.00	939,800.00	90.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,506,700.00	4,566,900.00	939,800.00	82.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,082,500.00	4,082,500.00		100
81835 - СУРГАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ					
1220	Тусламжийн орлого	11,764,100.00	10,191,900.00	1,572,200.00	86.64
122005	Төсвөөс санхүүжих	11,764,100.00	10,191,900.00	1,572,200.00	86.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,457,000.00	7,983,150.00	2,473,850.00	76.34
210104	Урамшуулал	10,457,000.00	7,983,150.00	2,473,850.00	76.34

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,307,100.00		1,307,100.00	
210201	Тэтгэврийн даатгал	888,800.00		888,800.00	
210202	Тэтгэмжийн даатгал	104,600.00		104,600.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	52,300.00		52,300.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	52,300.00		52,300.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	209,100.00		209,100.00	
БУСАД ЭХ ҮҮСВЭР					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
			33,379,654.52	(33,379,654.52)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл					
			35,158,367.96	(35,158,367.96)	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
71801 - сургуулийн өмнөх боловсрол					
80109 - тэш-ийн байгууллагуудын тогтмол зардал					
1220	Тусламжийн орлого	63,855,100.00	63,855,100.00		100
122005	Төсвөөс санхүүжих	63,855,100.00	63,855,100.00		100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,855,100.00	60,751,262.82	1,103,837.18	98.22
210301	Гэрэл, цахилгаан	5,530,100.00	4,492,448.82	1,037,651.18	81.24
210302	Тулш, халаалт	55,160,000.00	55,645,414.00	(485,414.00)	100.88
210303	Цэвэр, бохир ус	1,165,000.00	613,400.00	551,600.00	52.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,103,800.00	(1,103,800.00)	155.19
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,103,800.00	(1,103,800.00)	155.19
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		37.18	(37.18)	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		37.18	(37.18)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие

даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогтоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 17,106.8 мянган төгрөгөөр буюу 1.23 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	33,379.6	35,158.4	1,778.8
Авлага	35.5	35.5	0
Бараа материал	106,615.7	113,786.0	7,170.3
Үндсэн хөрөнгө	1,242,700.1	1,250,857.7	8,157.6
Нийт хөрөнгө	1,382,730.9	1,399,837.7	17,106.8
Өр төлбөрийн дүн	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,382,730.9	1,399,837.7	17,106.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,382,730.9	1,399,837.7	17,106.8

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,778.8 мянган төгрөгөөр, бараа материал 7,170.3 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 8,157.6 мянган төгрөгөөр тус тус өсчээ.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 106,615.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 48,458.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан бол 7,376.8 мянган төгрөгийн шатахуун, барилгын материал, хүнсний болон бусад хангамжийн материалыг хандив тусламжаар хүлээн авч 48,664.9 мянган төгрөгийн зарцуулалт хийжээ. Оны эцэст 113,786.0 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооллогын бүртгэл хөтөлж, тооцоог бодсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 25,265.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг хандив тусламжаар хүлээн авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 17,108.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант оны эцэст өмнөх оны 35.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 599,850.3 мянган төгрөгөөр, зардлыг 599,850.3 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээнд 502,615.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 63,855.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 564,692.1 мянган төгрөг буюу 94.13 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 31,263.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2,315.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 803.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 9,209.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн бол хангамжийн материалын зардлыг 5,192.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,134.5 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөрг а хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол	535,995.2	500,837.0	35,158.2	93.44
80233	Хүүхэд хамгааллын зардал	484.7	484.7	0	100
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	943.4	942.1	1.3	99.86
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	34,229.8	33,426.3	803.5	89.04
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,088.5	2,088.5	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	946.4	929.6	16.8	98.2
81833	Явуулын багшийн үйлчилгээ	3,564.1	3,550.2	13.9	99.3
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	481,974.2	451,432.4	30,541.8	93.6
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	11,764.1	7,983.1	3,781.0	67.8
Дүн		535,995.2	500,837.0	35,158.2	93.44
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109	Тогтмол зардал	63,855.1	63,855.1	0	100
Нийт дүн		599,850.3	564,692.1		94.13

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 63,855.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 60,750.9 мянган төгрөг, урсгал засварын зардалд 3,104.2 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
	Их мянганы хишиг ХХК /шууд аргаар/	Дулаан халаалт	55,160.0	55,645.4
2	АУЭХС /шууд арга/	Гэрэл цахилгаан	5,530.1	4,492.4
3	8 аж ахуйн нэгж, 10 иргэнтэй /шууд аргаар/	Хоол хүнс, бусад бараа материал	49,173.0	39,160.0
ДҮН			109863,1	99,297.8

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 396,872.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 5,953.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 4,464.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Завханмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,818.6 мянган төгрөгийн алдаа илэрч 1,171.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2,646.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Бүлгийн багшийг арга зүйч албан тушаалд дэвшүүлэн ажиллуулж үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолын 4.4 "багш нь урамшуулал авч байх хугацаандаа өөр ажилд шилжин ажилласан тохиолдолд урамшууллыг зогсооно", БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалын 4.9 "багш нэмэгдэл авч байх хугацаандаа багш бус ажилд шилжин ажилласан тохиолдолд төрөөс санхүүжих урамшууллыг зогсооно" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж:

1. 2016 онд ашиглалтанд орсон 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын 2 давхрын ариун цэврийн ерөөний паар задарч ус алдсанаас болж 2 анги, биеийн тамирын заал, 1 ба 2 давхрын коридор усанд автаж ихээхэн хохирол учирснаас болж ажилчдыг 2024 оны 2 дугаар сараас эхлэн ээлжээр эргүүлд гаргаж илүү цагийн мөнгө олгосон боловч эрхлэгчийн тушаалгүй, эрхлэгч нь холбогдох төсөв захирагчийн тушаалгүйгээр авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Илүү цагийн мөнгийг аливаа шийдвэргүйгээр хавтгайруулан олгохгүй байх

2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 52 нэр төрлийн 49.984.0 төгрөгийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдсэн үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шитгэлээрээ анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Дээрхи хөрөнгийг акталж, устгах, дахин үнэлүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

